



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 11 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Засгийн газар” гэснийг “энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компани” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.7 дахь заалтын “эсэх асуудлаар” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР